



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Даланжаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/8/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2 Сумын ТТЗ-ийн эрх зорилго, хууль эрх зүй.	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө	15
3.5.3 Авлага.....	16
3.5.4 Урьдчилгаа	16
3.5.6 Бараа материал	16
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	17
3.5.8 Өр төлбөр.....	17
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5.10 Орлогын данс	18
3.5.11 Зардлын данс.....	18
3.5 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	18
3.7 Шилэн дансны мэдээлэл	20
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	20
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	21
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	21
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.БЭХБАТ ТАНАА**

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.05.25 № 1-6/319

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	583,503.64	1,252,502.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,513.71	619,066.47
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,513.71	619,066.47
31210	Төгрөг	142,513.71	619,066.47
31211	Төрийн сангийн харилцах	142,513.71	619,066.47
33	АВЛАГА	157,446.61	314,999.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	33,292.69
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	226.36
33500	Бусад авлага	3,747.60	173,566.12
33510	Байгууллагаас авах авлага	3,747.60	173,566.12
33600	Зээлийн авлага	153,699.01	107,913.83
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	153,699.01	107,913.83
33612	Хувь хүмүүст олгосон зээл	153,699.01	107,913.83
34	УРЬДЧИЛГАА	20,552.83	31,750.00
34600	Урьдчилж гарсан зардал	20,552.83	31,750.00
35	БАРАА МАТЕРИАЛ	262,990.50	286,686.53
35100	Түүхий эд материал	43,690.54	61,975.65
35110	Тусгай зориулалттай материал	25,912.49	32,087.52
35130	Эм боох материал	17,778.05	29,888.13
35400	Хангамжийн материал	217,645.40	223,047.84
35410	Бичиг хэргийн материал	4,136.10	5,967.70
35420	Аж ахуйн материал	156,366.55	175,757.72
35430	Сэлбэг хэрэгсэл	4,417.53	5,098.28
35440	Түлш, шатах тослох материал	14,457.30	3,089.15
35460	Хүнсний материал	7,117.91	1,499.90
35470	Бусад хангамжийн материал	31,150.01	31,635.09
35600	Мал амьтад	1,654.56	1,663.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,532,695.17	6,362,195.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,532,695.17	6,362,195.25
39200	Биет хөрөнгө	5,401,929.17	6,159,811.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,932,289.11	4,413,705.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,662.44	-156,991.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	338,046.93	343,917.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	-168,023.99	-193,366.07
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	586,413.36	655,879.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-323,641.64	-369,295.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	427,164.82	473,743.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-226,403.61	-246,793.15
39209	Зам, гүүрийн байгууламж	586,727.42	586,727.42
39210	Хуримтлагдсан элэгдэл	-157,959.13	-187,295.50
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13,702.00	13,702.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	553,367.63	847,749.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	-116,719.42	-123,175.98
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	64,821.14
39217	Ном	38,628.13	36,483.49
39300	Биет бус хөрөнгө	130,766.00	202,383.36
39301	Програм хангамж	11,612.26	19,458.26
39302	Хуримтлагдсан элэгдэл	-11,012.26	-11,598.81
39303	Бусад биет бус хөрөнгө	130,166.00	194,523.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,116,198.82	7,614,697.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,037.53	472,409.37
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,037.53	472,409.37
41300	Өглөг	15,037.53	472,409.37
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	161,744.58
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	3,747.60	0.00
41360	Бусад өглөг	11,289.93	310,664.79

41361	Байгууллагад төлөх өглөг	11,289.93	309,082.60
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1,582.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,101,161.29	7,142,287.89
51	Засгийн газрын хувь оролцоо	6,101,161.29	7,142,287.89
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,600,070.75	2,770,600.56
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,170,529.82	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,910,934.92	3,590,044.52
51210	Өмнөх үеийн үр дүн	2,627,572.26	2,548,917.91
51220	Тайлант үеийн үр дүн	283,362.66	1,041,126.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,625.80	781,642.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,116,198.82	7,614,697.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,096,523.25	4,085,278.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	312,533.19	385,643.75
110	Орлогын албан татвар	79,918.92	92,865.08
1100	Хувь хүний орлогын албан татвар	79,918.92	92,865.08
110002	Үйл ажиллагааны орлого	4,702.45	4,223.74
110003	Хөрөнгийн орлого	0.00	28,264.31
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,880.00	1,154.00
110008	Шууд бус орлого	72,336.46	59,223.02
113	Хөрөнгийн албан татвар	1,620.00	1,371.00
113002	Бууны албан татвар	1,620.00	1,371.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	230,994.28	291,407.67
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	229,794.28	290,466.12
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,754.97	3,961.32
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	175,861.74	250,999.81
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	50,177.57	35,505.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,200.00	941.55
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,200.00	941.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	440,073.81	683,845.06
120	Нийтлэг татварын бус орлого	440,073.81	683,845.06
120003	Торгуулийн орлого	8,700.00	4,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	431,373.81	22,623.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,295.61	7,828.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	753.50	10,743.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	417,324.70	0.00
1200046	Зээлийн хүүгийн орлого	0.00	4,051.64
120009	Бусад орлого	0.00	219.30
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	627,710.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	28,731.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,343,916.25	3,015,789.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,406,439.00	2,068,950.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,224,975.90	1,359,606.90
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	181,463.10	709,343.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,006.36	488,741.84
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,855.00	251,393.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,151.36	237,348.74
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	862,417.98	430,422.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	610,261.80	185,919.94

Даланжаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	5,073.38	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	247,082.80	244,502.40
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,052.91	27,674.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,052.91	27,674.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,805,641.64	2,971,096.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,805,641.64	2,971,096.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,191,904.47	2,871,419.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,179,676.16	1,346,006.80
210101	Үндсэн цалин	1,022,570.47	1,047,410.80
210102	Нэмэгдэл	84,319.42	199,354.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,796.50	3,792.00
210104	Урамшуулал	62,269.78	80,961.02
210105	Гэрээт ажлын хөлс	6,720.00	14,488.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,582.84	170,198.08
210201	Тэтгэврийн даатгал	103,919.24	117,939.06
210202	Тэтгэмжийн даатгал	11,582.27	13,844.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,766.82	10,665.88
210204	Ажилгүйдлийн даатгал	2,209.69	2,506.04
210205	Эрүүл мэндийн даатгал	22,104.82	25,242.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,321.12	239,554.46
210301	Гэрэл, цахилгаан	52,106.89	37,895.05
210302	Түлш, халаалт	79,302.34	198,291.07
210303	Цэвэр, бохир ус	3,911.88	3,368.33
2104	Хангамж, бараа материалын зардал	260,736.93	626,874.03
210401	Бичиг хэрэг	11,247.40	11,127.18
210402	Тээвэр, шатахуун	42,585.68	42,695.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,518.11	5,793.49
210404	Ном, хэвлэл	2,322.60	532.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,882.30	6,554.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,498.46	15,763.33
210408	Бараа материал акталсны зардал	0.00	26,825.69
210409	Бараа материал шилжүүлсний зардал	179,682.38	517,581.50
2105	Нормативт зардал	93,063.93	78,517.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,790.53	44,344.79
210502	Хоол, хүнс	70,620.90	33,911.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,652.50	261.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,291.39	20,172.13
210601	Багаж, техник, хэрэгсэл	120.32	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	883.55
210604	Урсгал засвар	19,171.07	19,288.58
2107	Томилолт, зочны зардал	12,039.69	6,047.90
210702	Дотоод албан томилолт	12,039.69	6,047.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,314.56	148,644.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,772.86	144,062.69
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	630.00	1,946.00
210803	Даатгалын үйлчилгээ	333.46	1,054.45
210804	Тээврийн хэрэгслийн татвар	357.00	729.92
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195.00	283.00
210807	Газрын төлбөр	26.24	568.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	268,877.85	235,404.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,314.73	8,261.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,056.90	5,413.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	255,506.22	221,729.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	613,737.17	99,677.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,056.07	20,165.70
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	800.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,676.00	14,836.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,580.07	5,329.20

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	581,474.15	36,040.86
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	469,857.80	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,616.35	36,040.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,206.95	43,470.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,206.95	43,470.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	290,881.61	1,114,182.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	445.80	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	445.80	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,964.75	73,055.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,964.75	10,266.46
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	62,788.93
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	283,362.66	1,041,126.61

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,728,921.36	3,316,930.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	312,533.19	385,643.75
110	Орлогын албан татвар	79,918.92	92,865.08
1100	Хувь хүний орлогын албан татвар	79,918.92	92,865.08
110002	Үйл ажиллагааны орлого	4,702.45	4,223.74
110003	Хөрөнгийн орлого	0.00	28,264.31
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,880.00	1,154.00
110008	Шууд бус орлого	72,336.46	59,223.02
113	Хөрөнгийн албан татвар	1,620.00	1,371.00
113002	Бууны албан татвар	1,620.00	1,371.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	230,994.28	291,407.67
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	229,794.28	290,466.12
118001	Улсын тэмдэгийн хураамж	3,754.97	3,961.32
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	175,861.74	250,999.81
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	50,177.57	35,505.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,200.00	941.55
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,200.00	941.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,724.32	73,494.08
120	Нийтлэг татварын бус орлого	68,724.32	73,494.08
120003	Торгуулийн орлого	8,700.00	4,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,024.32	68,714.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,174.49	54,145.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	849.83	10,743.85
1200046	Зээлийн хүүгийн орлого	0.00	3,825.28
120009	Бусад орлого	0.00	219.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,347,663.85	2,857,792.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,406,439.00	2,068,950.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,224,975.90	1,359,606.90
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	181,463.10	709,343.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,006.36	330,744.86
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,855.00	251,393.10

Даланжаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,151.36	79,351.76
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	866,165.58	430,422.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	610,261.80	185,919.94
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	8,820.98	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	247,082.80	244,502.40
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,052.91	27,674.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,052.91	27,674.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,532,474.39	2,294,489.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,532,474.39	2,294,489.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,914,448.63	2,194,535.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,176,943.71	1,376,820.42
210101	Үндсэн цалин	1,019,880.52	1,069,330.11
210102	Нэмэгдэл	84,319.42	203,762.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,796.50	3,792.00
210104	Урамшуулал	62,227.28	85,447.60
210105	Гэрээт ажлын хөлс	6,720.00	14,488.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,427.88	170,198.08
210201	Тэтгэврийн даатгал	103,666.53	117,638.63
210202	Тэтгэмжийн даатгал	11,574.13	13,760.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,557.73	10,704.14
210204	Ажилгүйдлийн даатгал	2,238.26	2,537.78
210205	Эрүүл мэндийн даатгал	22,391.23	25,556.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,879.43	229,666.66
210301	Гэрэл, цахилгаан	52,106.89	37,895.05
210302	Түлш, халаалт	73,523.55	188,403.27
210303	Цэвэр, бохир ус	5,248.98	3,368.33
2104	Хангамж, бараа материалын зардал	65,990.60	75,070.33
210401	Бичиг хэрэг	9,517.25	11,225.43
210402	Тээвэр, шатахуун	35,643.59	39,450.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,554.41	6,239.99
210404	Ном, хэвлэл	2,346.00	734.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,184.60	7,416.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,744.75	10,003.11
2105	Нормативт зардал	114,349.60	68,654.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,100.16	31,167.69
210502	Хоол, хүнс	72,121.90	28,104.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,127.55	9,382.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,969.62	33,857.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,761.37	5,158.00
210602	Тавилга	7,930.00	685.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	11,198.40
210604	Урсгал засвар	16,278.25	16,815.40
2107	Томилот, зочны зардал	12,039.69	6,047.90
210702	Дотоод албан томилот	12,039.69	6,047.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,618.43	199,908.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,076.73	195,111.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	630.00	2,162.00
210803	Даатгалын үйлчилгээ	333.46	1,054.45
210804	Тээврийн хэрэгслийн татвар	357.00	729.92
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195.00	283.00

210807	Газрын төлбөр	26.24	568.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,229.66	34,311.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,507.56	15,538.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,722.10	18,773.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	618,025.77	99,954.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,597.07	20,442.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,676.00	14,836.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,921.07	5,606.20
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	585,221.75	36,040.86
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	469,857.80	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,616.35	36,040.86
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,747.60	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,206.95	43,470.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,206.95	43,470.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	196,446.96	1,022,440.63
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	271,761.55	545,887.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	271,761.55	545,887.87
2200	Дотоод эх үүсвэрээр	271,761.55	545,887.87
223001	Бусад хөрөнгө	188,945.27	275,878.68
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	82,816.28	270,009.19
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-271,761.55	-545,887.87
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-75,314.59	476,552.76
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	217,828.29	142,513.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,513.71	619,066.47

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,770,600.56	781,864.19	2,265,333.87	5,817,798.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	362,238.39	362,238.39
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,770,600.56	781,864.19	2,627,572.26	6,180,037.01
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-362,238.39	0.00	-362,238.39
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	283,362.66	283,362.66
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,770,600.56	419,625.80	2,910,934.92	6,101,161.29
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,770,600.56	419,625.80	2,910,934.92	6,101,161.29

Даланжаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	362,036.20	-362,036.20	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,770,600.56	781,662.01	2,548,898.71	6,101,161.29
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-19.20	19.20	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,041,126.61	1,041,126.61
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,770,600.56	781,642.81	3,590,044.52	7,142,287.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,202,141.20	2,437,564.75	764,576.45	76%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,492,797.40	2,161,686.08	331,111.32	87%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,466,100.10	2,143,573.38	322,526.72	87%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,405,804.20	1,372,767.62	33,036.58	98%
210101	Үндсэн цалин	1,093,916.90	1,065,277.31	28,639.59	97%
210102	Нэмэгдэл	203,762.60	203,762.60	0.00	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,280.00	3,792.00	1,488.00	72%
210104	Урамшуулал	87,724.70	85,447.60	2,277.10	97%
210105	Гэрээт ажлын хөлс	15,120.00	14,488.11	631.89	96%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,919.80	169,699.98	8,219.82	95%
210201	Тэтгэврийн даатгал	121,648.60	117,294.14	4,354.46	96%
210202	Тэтгэмжийн даатгал	14,041.50	13,720.20	321.31	98%
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,280.70	10,671.72	608.98	95%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,813.50	2,530.45	283.05	90%
210205	Эрүүл мэндийн даатгал	28,135.50	25,483.48	2,652.03	91%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,300.00	249,666.66	23,633.34	91%
210301	Гэрэл, цахилгаан	45,103.10	37,895.05	7,208.05	84%
210302	Түлш, халаалт	221,437.40	208,403.27	13,034.13	94%
210303	Цэвэр, бохир ус	6,759.50	3,368.33	3,391.17	50%
2104	Хангамж, бараа материалын зардал	74,634.90	71,893.88	2,741.02	96%
210401	Бичиг хэрэг	11,113.90	11,080.43	33.47	100%
210402	Тээвэр, шатахуун	39,137.60	36,576.57	2,561.03	93%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,093.80	6,053.69	40.11	99%
210404	Ном, хэвлэл	1,215.30	1,120.11	95.19	92%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,043.30	7,036.78	6.52	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,031.00	10,026.31	4.69	100%
2105	Нормативт зардал	107,680.20	55,300.27	52,379.93	51%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,064.70	18,063.69	1.01	100%
210502	Хоол, хүнс	80,229.90	27,854.08	52,375.82	35%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,385.60	9,382.50	3.10	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,540.00	120,421.41	118.59	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,950.00	18,949.90	0.10	100%
210602	Тавилга	39,793.10	39,711.00	82.10	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,000.00	9,998.40	1.60	100%
210604	Урсгал засвар	51,796.90	51,762.11	34.79	100%
2107	Томиллолт, зочны зардал	9,591.20	4,911.40	4,679.80	51%

Даланжаргалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	9,591.20	4,911.40	4,679.80	51%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,134.30	64,773.32	197,360.98	25%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,099.30	59,975.91	197,123.39	23%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,204.00	2,162.00	42.00	98%
210803	Даатгалын үйлчилгээ	1,110.00	1,054.45	55.55	95%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	832.00	729.92	102.08	88%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	305.00	283.00	22.00	93%
210807	Газрын төлбөр	584.00	568.03	15.97	97%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,495.50	34,138.83	356.67	99%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,101.00	13,100.33	0.67	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,394.50	21,038.50	356.00	98%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,697.30	18,112.70	8,584.60	68%
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,697.30	18,112.70	8,584.60	68%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,397.30	14,836.50	8,560.80	63%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300.00	3,276.20	23.80	99%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	709,343.80	275,878.68	433,465.13	39%
223001	Бусад хөрөнгө	709,343.80	275,878.68	433,465.13	39%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,202,141.20	2,893,227.24	308,913.96	90%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,095,976.20	2,025,480.24	70,495.96	97%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,386,632.40	1,316,136.44	70,495.96	95%
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	709,343.80	709,343.80	0.00	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	849,562.50	784,804.54	64,757.96	92%
320001	Орон нутгийн төсвөөс	849,562.50	784,804.54	64,757.96	92%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,796.80	27,674.80	122.00	100%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,796.80	27,674.80	122.00	100%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	228,805.70	55,267.66	173,538.04	24%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,162.90	54,145.66	1,017.24	98%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	1,122.00	-122.00	112%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	172,642.80	0.00	172,642.80	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	138,765.32	-138,765.32	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	598,253.09	-598,253.09	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	940.00	738.00	202.00	79%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	13.00	13.00	0.00	100%
610001	Төсвийн байгууллага	13.00	13.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	134.00	129.00	5.00	96%
620001	Удирдах ажилтан	14.00	14.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	64.00	61.00	3.00	95%
620003	Үйлчлэх ажилтан	53.00	52.00	1.00	98%
620004	Гэрээт ажилтан	3.00	2.00	1.00	67%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	659.00	467.00	192.00	71%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	433.00	467.00	-34.00	108%
630001	Төрийн өмчит ЕБС	433.00	467.00	-34.00	108%
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	226.00	0.00	226.00	0%
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	226.00	0.00	226.00	0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	134.00	129.00	5.00	96%

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	75.00	58.00	17.00	77%
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	7.00	5.00	2.00	71%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	15.00	13.00	2.00	87%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	33.00	-17.00	206%
650010	Гэрээт ажилтан	3.00	2.00	1.00	67%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	0.00	100%

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		330,744.86	-330,744.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		330,744.86	-330,744.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		317,223.32	-317,223.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,052.80	-4,052.8
210101	Үндсэн цалин		4,052.80	-4,052.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		498.10	-498.1
210201	Тэтгэврийн даатгал		344.49	-344.5
210202	Тэтгэмжийн даатгал		40.53	-40.5
210203	ҮОМШӨ-ний даатгал		32.42	-32.4
210204	Ажилгүйдлийн даатгал		7.33	-7.3
210205	Эрүүл мэндийн даатгал		73.33	-73.3
2104	Хангамж, бараа материалын зардал		3,585.25	-3,585.3
210401	Бичиг хэрэг		145.00	-145.0
210402	Тээвэр, шатахуун		2,873.95	-2,874.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		186.30	-186.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		380.00	-380.0
2105	Нормативт зардал		13,354.40	-13,354.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		13,104.00	-13,104.0
210502	Хоол, хүнс		250.40	-250.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,039.40	-11,039.4
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,550.00	-2,550.0
210602	Тавилга		1,389.60	-1,389.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,200.00	-1,200.0
210604	Урсгал засвар		5,899.80	-5,899.8
2107	Томилолт, зочны зардал		1,136.50	-1,136.5
210702	Дотоод албан томилолт		1,136.50	-1,136.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		280,062.87	-280,062.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		280,062.87	-280,062.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3,494.00	-3,494.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,494.00	-3,494.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,521.54	-13,521.5
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,700.00	-1,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,700.00	-1,700.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,821.54	-11,821.5

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		11,821.54	-11,821.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		330,744.86	-330,744.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		330,744.86	-330,744.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		251,393.10	-251,393.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		79,351.76	-79,351.8

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Бэхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-оос 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг гүйцэтгэв.

Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 03 сарын 04-ний өдөр 01/130 дугаар албан бичгээр Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.2 Сумын ТТЗ-ийн эрх зорилго, хууль эрх зүй.

Даланжаргалан сум тайлант оныг “Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх” жил болгон зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Даланжаргалан сумын ТТЗ-ийн бүрэн эрхийг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан байна. Үүнд:

1. Баг, хорооны Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;
2. Сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх
4. Эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох;
5. Албан татвар, төлбөр, хураамж хураах, зохих төсөвт шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авах;
6. Нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавьж, үйлчилгээний цагийн хуваарь тогтоох;
7. Хот, тосгоны иргэдийг цэвэр усаар хангах, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, мод, бут, сөөг, жимсний мод тарьж ургуулах, тохижуулах, гудамж талбайг гэрэлтүүлэх, үер усны хамгаалалт, далан суваг барих арга хэмжээ авах, түүнчлэн харьяалах нутаг дэвсгэрт нь барилга байгууламж барих, зам, холбооны шугам өөрчлөхөд оршин суугчдын санал авч шийдвэрлэх;
8. Хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтныг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;
9. Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64.4, 64.5-д заасан журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх;
10. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Даланжаргалан сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд сумын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Даланжаргалан сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж, “Дунд” гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,615.2 сая төгрөгийн 2 хувь буюу 32.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,971.1 сая төгрөгийн 2 хувь 59.2 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 142.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 619.1 сая төгрөг болж, 476.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	142.5	619.1	476.6	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	142.5	619.1	476.6	100

Эх сурвалж Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 450.0 сая төгрөг ОНХС-ийн дансанд, 95.4 сая төгрөг СХС-ийн дансанд, 52.8 сая төгрөг НСС-ийн дансанд, 11.8 сая төгрөг сумын ерөнхий орлогын дансанд, 9.0 хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төв, соёлын төвийн ахмадын санд байршиж байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 157.4 сая төгрөгөөс 315.0 сая төгрөг болж 157.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		33.3	33.3
Зээлийн хүүгийн авлага		0.2	0.2
Бусад авлага	3.7	173.5	169.8
Зээлийн авлага	153.7	108.0	-45,8
Дүн	157.4	315.0	157.6

Эх сурвалж Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын үлдэгдэлд 1 хүртэлх жилийн насжилттай 206.9 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 108.1 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Аймгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд сумын ЗДТГ-т барилгын засвар хийгдэж санхүүжилтийг 161.7 сая төгрөгийг дутуу олгосон байна. Олгоогүй санхүүжилтийн дүнгээр аймгийн ХО-аас авахаар авлага үүсгэсэн байна.
- Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн авлага 108.1 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- *Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацааны эцэст авлагатай байгаа ба энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг баримталж ажиллагаагүй байна.*

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 20.6 сая, эцсийн үлдэгдэл 31.8 сая төгрөг болж, 11.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	20.6	31.8	11.2
Дүн	20.6	31.8	11.2

Эх сурвалж: Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 31.8 сая төгрөгийн БОНСС-аас олгосон санхүүжилт байна. Энэ нь тайлант онд Даланжаргалан сумын Өнгөт багийн нутаг дэвсгэр дэх Цагаан овоо хэмээх газар 5.4 га, Улаан нуур хэмээх газар 3.5 га, Булшит улаан толгой хэмээх газар 4.5 га, Хөх хад хэмээх газар 1.9 га, Бичигт багийн нутаг дэвсгэр дэх Шувуут хэмээх газар 1.5 га, Ямаат хэмээх газар 4.5 га, нийт 23.9 га газарт нөхөн сэргээлт хийхээр тендер зарлан шалгаруулсан байна. Тус газар нөхөн сэргээх ажил гүйцэтгэх гэрээнд гэрээний нийт үнийн дүн болох 63.5 сая төгрөгийн 50 хувь болох 31.8 сая төгрөгийн ажил эхлэхээс өмнө олгоно гэж тусгасны дагуу “Шинэ баян булаг” ХХК-д шилжүүлж, тус дансанд бүртгэж, тайлагнасан байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 263.0 сая төгрөгөөс 286.7 сая төгрөг болж 23.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	43.7	62.0	18.3
Хангамжийн материал	217.6	223.0	5.4
Мал амьтад	1.7	1.7	0.0
Дүн	263.0	286.7	23.7

Эх сурвалж Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд 242.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 28.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн болон хандиваар хүлээн авсан байна. Мөн 217.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 30.5 сая төгрөгийн бараа материалыг акталж, шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь тайлант онд тооллогоор илэрсэн 2 төлөг данс бүртгэлд тусгаж, 9 төлөг нас дэвшүүлж бүртгээгүй байна

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,532.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,362.2 сая төгрөг болж 829.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,401.9	6,159.8	757.9
Биет бус хөрөнгө	130.8	202.4	71.6
Дүн	5,532.7	6,362.2	829.5

Эх сурвалж Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 270.0 сая төгрөг, үнэ төлбөргүй /ОНХС-ийн хөрөнгө оруулалт, ТАХ/ болон хандиваар авсан 713.1 сая төгрөг, шилжүүлсэн авсан 161.7 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 0.1 сая төгрөг, шилжүүлсэн 20.6 сая төгрөг, акталсан 91.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засаг даргын тамгын газарт элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн 152.6 сая төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд анхны өртгөө нөхсөн 4 төрлийн хөрөнгө ашиглагдаж байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 472.4 болж, 457.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	15.0	472.4	457.4	100
Нийт дүн	15.0	472.4	457.4	100

Эх сурвалж Даланжаргалан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд аймгийн хөрөнгө оруулалтаар сумын ЗДТГ-ын барилгын засварын ажлын санхүүжилт 161.7 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлогын албан татвар	4.4	4.2	-0.2	96%
2	Бусад татвар	30.0	59.2	29.2	197%
3	Бууны татвар	1.9	1.4	-0.5	73%
4	Улсын тэмдэгтийн хураамж	2.5	4.0	1.5	158%
5	Хог хаягдал үйлчилгээний хураамж	44.9	35.5	-9.4	79%
6	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	252.4	251.0	-1.4	99%
7	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1.5	1.1	-0.4	75%
8	Ус рашааны төлбөр	1.2	0.9	-0.3	78%
9	Хадгаламжийн хүүгийн орлого	26.8	28.3	1.5	106%
10	Хөрөнгө борлуулсны орлого	2.5	1.2	-1.3	46%
11	Хүү торгуулийн орлого	2.5	4.6	2.1	182%
12	Нэр заагдаагүй орлого	-	0.2	0.2	
Нийт орлого		370.6	391.3	20.7	106%

- Үйл ажиллагааны орлогын албан татвар 4 хувиар тасарсан нь тайлант оны иргэн, ААНБ-ын үйл ажиллагаатай холбоотойгоор, бууны татвар 27 хувиар тасарсан нь бууны шинэчилсэн тооллогоор бууны бүртгэл давхардсан, үрэгдсэнийг бүртгэлээс хассанаар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 21 хувиар, ус рашааны төлбөр 22 хувиар тасарсан нь цар тахалтай холбоотойгоор нүүрс болон жоншны баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа зогссоноор, хөрөнгө борлуулсны орлого тайлант оны иргэдийн худалдан борлуулах үйл ажиллагаа бага байсантай холбоотой байна.
- Бусад татвар өмнөх оны татварын үлдэгдлийг нөхөн төлүүлснээр, улсын тэмдэгтийн хураамж нотариатын үйлчилгээгээр, хадгаламжийн хүүгийн орлогын тайлант оны хадгаламжийн хэмжээгээр, хүү торгуулийн орлого цагдаагийн торгуулийн орлогоор тус тус давж биелсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг аудитын явцад ирүүлээгүй байна. Энэ талаар тодруулахад ТТЗ-ийн төсвийн төслийг нэгтгэгдсэн дүнгээр боловсруулагддаггүй, байгууллага тус бүрээр боловсруулан хүргүүлдэг гэсэн тайлбарыг өгч байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 3,202.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,492.8 сая төгрөгийг урсгал зардалд, 709.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,096.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 849.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27.8 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 228.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,025.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 784.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27.7 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 55.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, нийт 1,966.7 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 177.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 51.3 сая төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүнг батлагдсан төсөвт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс их дүнгээр төлөвлөн баталсантай холбоотой байна. Мөн цар тахалтай холбоотойгоор сумын Соёлын төвийн үйл ажиллагаатай хязгаарлагдсантай холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 1.1 сая төгрөгийн сумын ЗДТГ орон сууц түрээслүүлсний орлогоор бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,437.6 сая төгрөг буюу 76 хувьтай байгаа нь боловсролын салбарын үйл ажиллагааг хязгаарлагдсантай холбоотойгоор зардал хэмнэгдсэн байна.

Урсгал санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 43.5 сая төгрөгийг улсын төсөвт, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 36.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, нийт 79.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 251.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 79.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 318.9 сая төгрөгийг зарцуулж, 11.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлээгүй мэдээлэл сумын Засаг даргын 4 захирамж байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	2		2				100
Зөвлөмж							
Нийт	2		2				100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, орон нутгийн тусгайн сангийн нийт 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 3 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3 дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 17.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14.2 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 2.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр:	ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ДГА-2021/8/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Даланжаргалан сумын ТТЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчил товч утга	мөнгөн дүн	аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	албан тушаал	овог нэр
	1	2	3	4	5
1	ЗДТГ: Өмнөх оны нэмэлт санхүүжилтийн авлагыг барагдуулж тухайн оны орлогоор бүртгэсэн	3,430.00	Аудитын явцад залруулав.	Дарга Нягтлан бодогч	Б.Оюунбямба Б.Бат-Оюун
2	ЗДТГ: Тайлант онд тооллогоор илэрсэн 2 төлөг данс бүртгэлд тусгаж, нийт 9 хурга, төлөгийн нас дэвшүүлэн бүртгээгүй байна.		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Оюунбямба Б.Бат-Оюун
3	ЗДТГ: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн 152.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Оюунбямба Б.Бат-Оюун
4	ЗДТГ: БҮТЭАЭЗүйлс данснаас 580.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан	580.00	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Оюунбямба Б.Бат-Оюун
5	ЕБС: Тайлант хугацааны эцэст авлагатай ажилласан байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Ганболд Ж.Мөнхсайхан
6	ЭМТ: Иргэн, ААНБ-аас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримт аваагүй байна. /Цахим Е баримтыг хангаж ажиллаагүй/		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Янжинлхам Б.Адьяасүрэн
7	ИТХ: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэр төрлийн хөрөнгө ашиглаж байна.	2,341.90	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Болдбаатар Б.Бат-Оюун
8	ОНХС: Сангийн өглөгийг буруу тооцоолсон байна.	9,761.40	Аудитын явцад залруулав.	Засаг дарга ТС-ийн мэргэжилтэн	Д.Бэхбат Б.Нямцэцэг
9	СХС: Санхүүгийн тайланд зээл болон зээлийн хүүгийн авлагыг буруу тайлагнасан байна.	758.50	Аудитын явцад залруулав.	Засаг дарга ТС-ийн мэргэжилтэн	Д.Бэхбат Б.Нямцэцэг
10	СХС: Зээлийн хүү болон алдангийн орлогыг буруу тооцоолсон байна.	226.40	Аудитын явцад залруулав.	Засаг дарга ТС-ийн мэргэжилтэн	Д.Бэхбат Б.Нямцэцэг
ДҮН		17,098.20			